



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/625

Мөрөн сум

Төсөвт өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4, 45 дугаар зүйлийн 45.1, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/51 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/51 дугаар тушаалаар эрх шилжиж ирсэн Сангийн сайдын багцад батлагдсан VI.2.1.1 хуулийн дугаартай Байгаль орчноо хамгаалах, загас үржүүлэх, загасчлах жуулчлалыг хөгжүүлэх төсөл (Хөвсгөл) –ийн хүрээнд нэмэлтээр хэрэгжүүлэх “Сургалт, тоног төхөөрөмжийн тохируулга, зүгшрүүлэлт, технологи шийдлийг нутагшуулах, байгаль орчныг хамгаалах” арга хэмжээний төсөвт өртгийг 165,053,381 (нэг зуун жаран таван сая тавин гурван мянга гурван зуун наян нэгэн) төгрөгөөр баталсугай.

2. Төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд шууд гэрээ байгуулан ажиллахыг аймгийн орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

3. Байгаль орчноо хамгаалах, загас үржүүлэх, загасчлах жуулчлалыг хөгжүүлэх төсөл (Хөвсгөл)-ийн хүрээнд хэрэгжүүлэх нэмэлт ажлын даалгаврыг боловсруулж батлуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал) -т даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ